



**“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР” /МИАТ/ ТӨХК-ИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024.01.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын иргэний агаарын тээвэр” /МИАТ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Танилцуулга

МИАТ ТӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 93,1%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МИАТ ТӨХК-ийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
36	25	9	2	-	-	-	95,3%	

МИАТ ТӨХК нь 2023 онд 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна.

Нийт 36 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 25 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 9 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 95,3%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Хүрэх түвшин	Ирүүлсэн биелэлт	Тасарсан шалтгаан нөхцөл
1	2.6. Зорчигчдод зориулсан цахим нэг цонхны	1 дүгээр улиралд: 2023 оны 1-4 сард miat.com цахим	Хэрэглэгчид хэзээ ч, хаана ч нислэгийн суудал захиалга хийх, тийз худалдан авах, цагийн хуваарь харах зэрэг олон	Гадаад хүчин зүйлээс



	үйлчилгээ нэвтрүүлэх	хуудсыг шинэчилнэ Жилийн эцсийн байдлаар: <i>miat.com</i> цахим хуудсаар виз мэдүүлэх, тийз авах, зочид буудал, унаа захиалах, аяллын даатгалын үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ	үйлчилгээг авах боломжтой <i>MIAT.com</i> цахим хуудас болон <i>MIAT</i> гар утасны аппликэйшнийг үйлчлүүлэгч онлайнаар тийз худалдан авах ажиллагааг хялбаршуулах, хайлтыг сайжруулах, ашиглахад илүү хялбар болгон 2023 оны 4 дүгээр сард бүрэн шинэчлэн, хөгжүүлж ашиглаж эхэлсэн. "Гадаадын иргэн харьяатын газар"-ын цахим визний платформ бүрэн хийгдэж дуусаагүй хүлээгдэж байгаа учраас <i>MIAT.com</i> цахим хуудсаар виз мэдүүлэх, унаа захиалах үйлчилгээний холболт хийгдээгүй байгаа. 70%	
2	2.15. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэлийг хангах	Жилийн эцсийн байдлаар: Батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	АНУ-ын чиглэлд тогтмол нислэг нээх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр компанид 6 дэд ажлын хэсэг байгуулагдан доорх чиглэлээр 101 төлөвлөгөөт ажлыг ИНЕГ-тай хамтран хийж байна. (Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай) 1. АНУ-ын Тээврийн яамнаас зөвшөөрөл /DOT economic authority approval or exemption/ авах 2. АНУ-ын FAA IASA шалгалтанд бэлтгэхэд ИНЕГ-ыг дэмжиж ажиллах 3. АНУ-ын FAR Part-145 Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжилтийг бэлтгэх 4. АНУ-ын FAR Part-129 гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжилтийг бэлтгэх 5. АНУ-ын Тээврийн аюулгүй байдлын алба TSA-наас батлах SP Security Program /Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр/-ийг боловсруулж батлуулах, "Чингис Хаан" нисэх буудалд хийгдэх LPT /Last Point of Departure/ аудитыг дэмжиж ажиллах 6. ИНЕГ-аас ETOPS/EDTO зөвшөөрөл авах АНУ-ын чиглэлд тогтмол нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Ирланд Улсын "AerCap" компаниас өргөн биет B787-9 /Dreamliner/ төрлийн 2 шинэ агаарын хөлгийг урт хугацааны түрээсээр авахаар гэрээ байгуулсан. Эхний 787-9 агаарын хөлгөө 2023.08.11-ний өдөр хүлээн	Удирдлага, зохион байгуулалт



			авсан Хоёр дахь 787-9 агаарын хөлгийг 2024 оны эхний улиралд багтаан хүлээн авна. Тус агаарын хөлгөөр 2024 онд АНУ-ын чиглэлд шууд нислэг үйлдэнэ. 70%	
3	3.12.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийг хэрэгжилтийг ханган, тайлагнах	Хагас жилийн байдлаар: 50% Жилийн эцсийн байдлаар: 100%	2023 онд компанийн хэмжээнд "Аюулгүй хөдөлмөрлөө" аяныг шинээр хэрэгжүүлэхээр 20 багц ажлын төлөвлөгөө боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. (Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай)"Аюулгүй хөдөлмөрлөө" аяны хүрээнд хэрэгжүүлж байгаа 20 ажлын төлөвлөгөөний явцын биелэлт, үр дүнгийн тайланг нэгтгэн гарган ЗТХЯ-ны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны Нарийн бичгийн даргад 2023.04.11, 2023.06.22, 2023.09.11, 2023.10.10, 2023.11.20-ны өдөр тус тус цахимаар gantsetseg@mrd.gov.mn хаягаар хүргүүлэн тайлагнасан. 70%	

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%			
5	4	1	-	-	-	94%	

2.3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%			
Төсөв/гүйцэтгэл	5	4	1	-	-	-	94,0	
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	4	3	1	-	-	-	92,5	
бусад	5	5	-	-	-	-	100,0	
Нийт	14	12	2	-	-	-	95,7	

2.4 Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%			
Нийт	33	28	1	2	2	-	88.8	



Хэрэгжилт хангалтгүй:

1/ Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ - 30%

2/ Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ – 0%

3/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан – 30%

4/ Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл – 0%

Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

ХШҮДАГ-аас “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай контрактын гэрээ байгуулахаас гадна компанийн үйл ажиллагааны менежментийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн бие даасан, тогтвортой байдал, тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн ЗТХЯ-тай хамтран гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажиллах зөвлөмж” өгсний дагуу МИАТ ТӨХК нь 2023 онд Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдаар хянуулж батлан ажилласан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) МИАТ ТӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 93,1% буюу эхний хагас жилээс 6,4%-иар өссөн дүнтэй байна.
- 2) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 36 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 25 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 9 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 95,3% буюу сайн хэрэгжсэн байна.
- 3) 2022 оны үйл ажиллагааг дүгнэн өгсөн 4, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэн өгсөн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.
- 4) МИАТ ТӨХК нь 2023 онд 859 тэрбум төгрөгийн орлого олж, 770 тэрбум төгрөгийн зардал гарган, 89 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна. Мөн 3223 удаагийн аялал үйлдэж, 895 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.
- 5) “Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 9 аймгийн чиглэлд долоо хоногийн 1-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхэлсэн, хоёр ширхэг 787-9 /Dreamliner/ төрлийн агаарын хөлгийг үйл ажиллагааны урт хугацааны түрээсээр авах гэрээг байгуулан эхний онгоцоо хүлээн авсан, “МИАТ Бизнес

лаунж” шинээр нээн зорчигч үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг нь гадаад, дотоодын зорчигчдодоо хүртээмжтэй, хямд, тав тухтай, шуурхай зорчих боломжийг олгон жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой ажил болжээ.

Санал, зөвлөмж

1. Ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилт бүрэн хэрэгжээгүйд анхаарч, шалтгааныг тогтоон тодорхой шийдэл гаргах;
2. Зорчигчдод зориулсан цахим нэг цонхны үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх, Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэлийг хангах зэрэг бүрэн хэрэгжээгүй ажлуудыг 2024 оны төлөвлөгөөнд тусган удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах;
3. 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан 2 дугаар сард багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах,
4. Аялал жуулчлалын бүс нутаг руу олон улсын шууд нислэг /тухайлбал Эрээн-Мөрөн чиглэлд/ үйлдэх боломжийг судлах, 2024 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;
5. 2024 онд хэрэгжүүлэх 5 онцлох ажлыг тодорхойлон хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган сар бүр ЗТХЯ-д тайланг ирүүлэх;

ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ИНБЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОДХҮҮ

МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Б.МӨНХТАМИР

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА

**МИАТ ТӨХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2023 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд үнэлсэн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/							Хугацаа болгоүй	Үнэлгээгүй	
				Дундаж хувь	100	90	70	50	30	0			
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	36	36	95.3	25	9	2	-	-	-	-	-	-
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	5	5	94.0	4	-	1	-	-	-	-	-	-
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	14	14	95.7	12	-	2	-	-	-	-	-	-
5	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	33	33	88.8	28	-	1	-	2	2	2	-	-
Нийт		88	88	93.1	69	9	6	-	2	2	2	-	-